



ШУТИС-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН
ДОТООД ХЯНАЛТЫН БАГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН


Зорилго

Сургуулийн дотоод хяналт шалгалт нь Монгол улсын хууль, тогтоомж болон ШУТИС болон ӨмТДС-ийн дүрэм журам, шийдвэрийн хэрэгжилт, санхүү, өмч хөрөнгийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчил дутагдлыг илрүүлж арилгуулах замаар хууль тогтоомж, стандартыг нийтээрээ даган мөрддөг, хэрэгжүүлдэг, хэвшил тогтооход оршино.



2024.01.01-2024.12.31

№	Ажлын чиглэл	Үйл ажиллагаа	Хугацаа	Хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүн	Баталгаажуулалт
1	Дотоод хяналт шалгалтын зарчим, зорилго	Дотоод хяналтын багийн хурал хийж, өнгөрсөн жилийн төлөвлөгөөний тайлан хэлэлцэх, төлөвлөгөө гаргах	2024.01	Сургуулийн захирлын 2024 оны 03 сарын 11 өдрийн А/17 тушаалаар 5-н хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын багийг байгуулан ажиллаж дотоод хяналтын төлөвлөгөө гаргасан.	2023 оны дотоодын хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн хэлэлцүүлэг хийж 2023 болон 2024 оны жилийн ажлын үр дүнг харьцуулан харахад ажлын бүтээмж нэмэгдсэн үр дүнтэй байна.
		Ажлын төлөвлөгөөг гаргаж хамт олонд танилцуулах	2024	2024 оны ажлын жилийн төлөвлөгөөг багаараа боловсруулж хамт олонд танилцуулж хамт олны санал хүсэлтийг хүлээн авч төлөвлөгөөндөө тусган ажилласан.	Дотоод хяналтын багийн үйл ажиллагаа тогтмолжиж, сургуулийн бүх ажиллагаа хэвийн, чанартай, хэрэгжихэд дэмжлэг болно.
2	Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нэгж, ажилтан,	Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг өөрийн байгууллагад сурталчлах, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах	2024.05.13	"Боловсролын багц хуулийг сурталчлах, таниулах, тэдгээрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Боловсролын шинжлэх ухааны яам, Боловсролын Ерөнхий газраас зохион байгуулсан сургалтад хамрагдаж хамт олондоо мэдээллийг хүргэсэн.	2024 оны 05 сарын 13 өдөр Даланзадгад сумын цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, сургуулийн захирал, нийгмийн ажилтан, багш нар болон ӨмТДС - иас сургалтын албаны ажилтан, Коосэн сургалтын менежер нар хамрагдсан.
		Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	2024.02.12	Үндсэн болон гэрээтээр багшилж буй багш нарын хичээлийн хөтөлбөр боловсруулалт, ажлын тайлан бичих зөвлөмж өгч ажилласан. Мөн хөтөлбөрийн агуулгын хүрээнд хичээл оролтод хяналтад тавьж багш нарт мэргэжлийн зөвлөгөө өгч ажилласан байна.	1. Багш нар батлагдсан сургалтын хөтөлбөрөө гарын доор ашиглах хэрэгтэй байна. 2. Коосэн технологийн коллежийн багш нарыг журналтай болгох шаардлагатай байсан. 3. Коосэн коллежийн оюутны хувцас жигдрэлтэд анхаарах шаардлагатай байсан. 4. Анги танхимын ширээ сандал болон эд хөрөнгийн эвдрэл хэмхрэл их байсан тул засаж сайжруулахад анхаарч ажиллах зөвлөмж өгч ажилласан.

	түүний эрх үүрэг			Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх, шалгалтын баримт материалыг албажуулан архивлах.	2024	Албатууд хичээлийн жилд бичиг баримт болон мэдээллийн сангийн бүрдүүлэлт хийсэн байна. Үүнд: Сургалтын алба: оюутны бүртгэл мэдээлэл, багшийн сургалтын материал, цаасан болон цахим архив үүсгэсэн; Номын сан: Номын фондын баяжуулалт баримт бичиг мэдээллийн сангийн бүрдүүлэлт, архивласан; Сүлжээний инженер:Сургалтын цахим орчны мэдээ мэдээллийг баримтжуулан архивлаж, нийтэд түгээсэн; Санхүүгийн алба: Шилэн данс болон ажлын хөлс, цалин урамшууллын тооцоо, бараа эд хөрөнгийн бүртгэл, архив болон засвар үйлчилгээ хийж ажилласан үр дүнтэй байна.	
3	4.1.1 ШУТИС-ийн хэмжээнд мөрдөгдөх хууль, дүрэм журам, Сургуулийн захирлын тушаал шийдвэр эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэнд хяналт тавих	Сургуулийн хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм журмын боловсруулалт, хэрэгжилтэд хяналт тавих	2024	Сургуулийн хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм журмын боловсруулалт, хэрэгжилтэд хяналт тавихад: 1. Хөдөлмөрийн дотоод журам, 2. Өмнөговь аймаг дахь Технологийн Дээд Сургуулийн дүрэм, 3. Багш шилжин ажиллахад нийгмийн батламж хангах журам, 4. Бакалаврын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам,			
		ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь технологийн дээд сургуульд суралцах гэрээ байгуулах	2024.09-2025.01	ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь технологийн дээд сургуульдад суралцах гэрээ байгуулахад ӨМТДС - д 2024-2025 оны хичээлийн жилийн А улиралд нийт ЕБС - ээс шинээр 45 элсэгч элсэн гэрээ байгуулсан байна. Харин өвлийн элсэлтээр иргэнээр суралцагчаас 8, төв ШУТИС-ийн бүрэлдэхүүн болон дотоодын бусад сургуулиудаас шилжин ирж суралцсан 7 оюутантай "Цахим гэрээ" байгуулалтад хяналт тавьж ажилласан байна.	UNIMIS системд зөвлөх багшийг бүртгэж багшийн вэб дээр "Цахим гэрээ" байгуулсан оюутны баталгаажилт гэрээг сургалтын албанаас хянаж ажилласан. 1. УУАТ мэргэжлийн оюутнуудын зөвлөх багшаар Э.Энхцэцэг 2. ЦИ мэргэжлийн оюутнуудын зөвлөх багшаар Т.Билгүүн 3. УУАТ 30+5 ангийн зөвлөх багшаар М.Цэрэнтогтох 4. УУАТ эчнээ ангийн зөвлөх багшаар Б.Хулан 5. ЦИ эчнээ ангийн зөвлөх багшаар Т.Мөнхтуяа нар гэрээний баталгаажилтад зөвлөгөө өгч ажилласан.		
		Мэдээллийн сан бүрдэлтэд хяналт тавих		Мэдээллийн сан бүрдэлтэд хяналт тавихад: *Багш ажилчдын судалгаа гарган мэдээллийн сан бүрдүүлж байна. *Багш нарт ӨМТДС-ийн код үүсгэн багшийн вэб нээн ажиллаж байна. *Хүний нөөцийн бүрдүүлэлт хийж гэрээ болон баримт бичгийн архив хийн ажиллаж байна.			

4	4.1.3 Сургалтын үйл ажиллагаа, сурлагын чанарт хяналт тавих	Хичээлийн бэлтгэл, хичээлийн оролт гаралтанд хяналт тавих	2024	Бакалаврын болон дэд бакалаврын хичээл сургалтад хяналт тавьж улирлын эхэнд ШУТИС - ийн сургалтын нэгдсэн хуанлийг дагаж мөрдөн хичээлийн хуваарийг гарган захирлаар батлуулж багш суралцагчдын цагийн менежмент болон хичээл зохион байгуулалтад анхааран ажилласан. Ажлын өдрүүдэд сургуулийн захиргаа, дотоод хяналтын багаас өглөөний хичээл эхлэлт суралцагчдын хоцролт, багшийн цагийн менежмент болон анги танхимын зохион байгуулалтад хяналт тавьж ажиллаж байна.	2.8 дээш голчтой суралцсан оюутан Засгийн газрын тэтгэлэгт - 86, -3.0 дээш голчтой суралцсан оюутан Орон нутгийн тэтгэлэгт - 77 оюутан хамрагдаад байна. - 80-89% В үнэлгээтэй суралцсан оюутанд 25% тэтгэлэгт хамруулсан. /А улиралд -11, В улиралд-15 суралцагч/ - 90% дээш В үнэлгээтэй суралцсан оюутанд 50% тэтгэлэгт хамруулсан. /А улиралд-10, В улиралд-20 суралцагч/
		Оюутны эзэмшсэн мэдлэг чадварын ахицыг тооцон мөрөөр хэрхэн ажиллаж байгаа байдалд хяналт тавих	2024.1	Оюутны эзэмшсэн мэдлэг чадварын ахицыг тооцон түүний мөрөөр хэрхэн ажиллаж байгаа байдалд хяналт тавихад: *2024 оны хичээлийн жилд Хичээл сонголт - 2 хийж суралцсан оюутны А болон В улирлын дүнгийн нэгтгэл хуудсанд багш нар баталгаажуулалт хийсэн; *Оюутны дүн улирал бүрийн дүн мэдээг системээс татаж голч дүнгийн тушаал гарган Голч дүн 0.7 доош суралцсан оюутнуудад сануулга болон зөвлөмж өгсөн; ШУТИС - ийн дүрмийн 10.2 дахь заалт, ШУТИС - ийн суралцагчдад тэтгэлэг, кредитийн урамшуулал олгох журмын 6.4.5, 6.4.6, 6.4.7, 6.4.8, 6.4.10 заалтуудад үндэслэн клуб дугуйлан, зөвлөл ажиллуулсан оюутан болон коосэн коллежийн сурлагын амжилт гаргасан суралцагчдад тэтгэлэг, урамшуулал олгон ажилласан; -2.8 дээш голчтой суралцсан оюутан Засгийн газрын тэтгэлэгт - 86, -3.0 дээш голчтой суралцсан оюутан Орон нутгийн тэтгэлэгт - 77 оюутан хамруулсан; - 80-89% В үнэлгээтэй суралцсан оюутанд 25% тэтгэлэгт А улиралд -11, В улиралд-15 суралцагч хамруулсан; - 90% дээш В үнэлгээтэй суралцсан оюутанд 50% тэтгэлэгт А улиралд-10, В улиралд-20 суралцагч хамруулсан үр дүнтэй байна.	 Оюутны кредит, голч дүнгийн тушаалд үндэслэн тэтгэлэгт хамруулсан байдал
		Багш бүрийн хөтөлбөртэй танилцах	2024.02	Багш бүрийн хөтөлбөртэй танилцаж 2024 оны хичээлийн жилд ажилласан багш нарын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг сургалтын албанаас баталгаажуулж хичээлийн агуулга болон зохион байгуулалтад хяналт тавьж, сургуулийн захиргаанаас зөвлөмж өгч ажилласан.	Үндсэн болон гэрээт багш нар цахим хичээл, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, материал хэрэглэгдэхүүнийг Moodle програмд байршуулж байна. http://um-lms.edu.mn/ https://www.facebook.com/profile.php?id=100084539363947

Сургуулийн хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтад хяналт тавих	2024.01	2024 оны хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт хийхдээ холбогдох журмыг баримтлан дараах хүний нөөцийн бүрдүүлэлт хийн ажиллажээ. *Ажлын байрны зарын дагуу Коосэн сургалтын менежер -1 Гадаад харилцаа, хүний нөөц, оюутны хөгжил хариуцсан мэргэжилтэн-1 Япон хэлний багш - 1 Мэдээллийн технологийн багш - 3 Уул уурхайн ашиглалтын технологийн багш - 1 Ерөнхий эрдмийн багш - 3 Нярав - 2 Жижүүр - 2 Үйлчлэгч - 1	<i>*Гэрээт багшийн журам,</i> <i>*Профессор багш нарын ажлын кредит тооцох журам,</i> <i>*Мэргэжлийн ба техникийн боловсролын сургалтын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам,</i> <i>*Өргөдөл, гомдол хүлээн авч, шийдвэрлэх сонгон шалгаруулалтын журмуудыг баримтлан ажилласан.</i>
Ажилтан албан хаагчийн ажлын цаг ашиглалтад хяналт тавих	2024	Ажилтан албан хаагчийн ажлын цаг ашиглалтад хяналт тавихад: ӨмТДС нь цаг бүртгэлийн TIMELY системийн багш ажилчдын ажлын цагийн бүртгэлийг хийж хянан ажилласан байна. Мөн тухайн өдрийн ажлын тайланг Facebook аппликейшн ашиглан тайлагнаж санал, сэтгэгдлээ хуваалцан ажиллаж байна.	Цаг бүртгэлийн системийг ашиглан ажилчдын илүү, тасалсан цагийн бүртгэл томилолт, амралт болон чөлөөний хугацааг тооцож үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд анхааран ажиллаж байна.
Номын сангийн хүртээмж, үйл ажиллагаанд хяналт хийх	2024 оны А, В улиралд	Номын сангийн хүртээмж, үйл ажиллагаанд хяналт хийхэд: Төсвийн хүрээнд мэргэжлийн болон ерөнхий эрдмийн хичээлүүдийн номыг худалдан авч хичээл сургалтын үйл ажиллагаанд ашигласан байна. Үүнд: *Мэргэжлийн ном 14 нэр төрлийн 134 ширхэг - 4665750 *Ерөнхий эрдмийн: -11-р анги - 15 нэр төрлийн 570 ширхэг - 3651800, -10 анги-15 нэр төрлийн 600 ширхэг - 3588000 Нийт 44 нэр төрлийн 1304 ширхэг - 11905550 төгрөгний ном худалдан авч номын фонд баяжуулалт хийсэн байна.	 <i>Номын сангийн фонд баяжуулалт хийн ажиллаж байна.</i>
Багшийн ачаалал тооцсон байдалд хяналт хийх	2024 оны А, В улиралд	Багшийн ачаалал тооцсон байдалд хяналт хийхэд: *Дээд боловсролын багшийн В цаг болон гүйцэтгэлийн кредитийг тооцон олгох журмыг үндэслэн дээд болон коосэн хөтөлбөрт багшлаж байгаа багш нарын цагийн тооцоонд сургалт чанарын албанаас хяналт тавин ажилласан байна. *Улирал бүрийн хичээлийн хуваарийн дагуу I-XVI долоо хоногт ажилласан багш нарын кредитийн гүйцэтгэлийн Коосэн коллежийн багш нарын тооцоог сургалтын менежер Б.Цэрэнсүрэн, дээд сургуулийн кредитийн тооцоог сургалт чанарын албаны дарга баталгаажуулан сургуулийн захирлаар батлуулан олгосон байна.	 <i>Багшийн цагийн ачаалал тооцсон маягтууд</i>

5	4.1.4 Багш, оюутан, ажилтны хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, сургалтын орчны стандартад хийх хяналт шалгалт	Сургуулийн гадна орчин болон дотор орчны тохижилт эрүүл, аюулгүй байдалд хяналт тавих	2024.11.01	1.Өмнөговь аймгийн байгаль орчны газраас байгууллагын нийтийн "Орчны хог цэвэрлэгээ" үйл ажиллагаанд багш, ажилчид болон нийт оюутан суралцагчдыг хамруулан ӨМТДС - ийн орчныг цэвэрлэж 800кг хогийг зориулалтын хогийн саванд хийж ачуулсан. 2.Багш ажилтан, суралцагчдын амралтын цагаар ашиглах зориулалтын дагуу сүүдрэвч хийж байршуулсан. 3. Жилээс жилд оюутны тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан хичээл сургалтын үйл ажиллагаанд ашиглах лаборатори болон анги танхимын тохижилт хийлээ. Үүнд: 1. Анги танхимд ширээ сандлыг шинээр худалдан авч тохижуулсан. 2. Тэндэрийн дагуу мэдээллийн технологийн лаборатори анги шинээр байгуулсан. 3. Сургуулийн үүдний "Угтах хэсэг"-ийг шинээр хийж хянах самбар, зохион байгуулалтын мэдээллийн самбарыг шинээр байршуулсан. 4. Багш ажилчдын албан хэрэгцээнд компьютер, канон болон принтерийг шинээр ашиглуулж байна.	 2024 онд шинээр байгуулагдсан лаборатори, анги танхим болон сургуулийн орчны тохижилт хийсэн байдал
			2024	1. Багш ажилчдын байранд шинээр зохион байгуулалт хийж сургуулийн зочид буудлыг тохижуулж ШУТИС-иас томилолтоор ирсэн багш нарыг байршуулж байна. 2. Политехникийн коллежийн оюутны байр болон гадуур түрээсийн байранд бусад орон нутгаас оршин сууж буй оюутнуудын амьдрах орчны тав тухыг хангаж ор, гудас, хувцасны шкаф, хичээл хийх ширээ сандлаар ханган ажилласан.	 Багш нарын өрөө болон оюутны дотуур байрны тохижилт
		Ажлын байрны эмх цэгц, ажилтны хувийн зохион байгуулалт	2024	Ажлын байрны эмх цэгц, хувийн зохион байгуулалтад хяналт тавьж ажиллахад: *Ажлын өдрүүдэд тэнхим болон сургалтын албанаас багш, ажилчид ээлжлэн хянагч багшаар ажиллаж сургалтын үйл ажиллагаа, сургуулийн дэг журмын зөрчлийг илрүүлэн санал, зөвлөмж өгч тухайн өдөр гарсан зөрчил, асуудлуудыг шийдвэрлэн ажилласан. *Өмнөговь аймгийн засаг даргын 2023 оны А/2211 дүгээр захирамжийн дагуу долоо хоног бүрийн Мягмар гарагт Монгол үндэсний хувцасаа өмсөж хэвшсэн. *Ажлын зохион байгуулалт, мэдээ мэдээллийг цаг тухайд нь хүргэж албатуудын уялдаа холбоотой ажиллах нөхцөл боломжуудыг эрэлхийлэн багаар харилцан хамтран ажиллах орчныг бүрдүүлэхэд дотоодын үйл ажиллагааны зохион байгуулалт болон цахим орчныг ашиглан мэдээ мэдээллийг хуваалцан ажилласан байна.	 Фэйж хуудас - ШУТИС-ын харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургууль Фэйсбүүк чат групп - ӨмТДС хамт олон Фэйсбүүк чат групп - ӨмТДС багш нар

6	4.1.5 Сургуулийн санхүүгийн бичиг баримт, бүрдэлтэнд хяналт тавих	Шилэн дансны мэдээ, мэдээлийг цаг хугацаанд үнэн зөв оруулж байгаа эсэхэд хяналт тавих, цалингийн нэгдсэн мэдээлэл хүн бүрт ирж байгаа эсэх	2024 сар бүрийн 8 өдөр	1. Шилэн дансанд оруулах ёстой мэдээллийг сар бүрийн 8-ны дотор оруулж хянан ажиллаж байна. 2. Багш ажилчдын цалин ажлын хөлсийг ажилтан бүрт цалин тооцсон тухай бүрт мэйлээр илгээн мэдээллэн ажиллаж байна.	
		Ажлын хөлс, ажлын хоног, үр дүнгийн тооцоог зөв бодсон эсэх, ажилтанд танилцуулж байгаа эсэх	2024	Ажлын хөлс, ажлын хоног, үр дүнгийн тооцоог зөв бодсон, ажилтанд танилцуулж байгаа эсэхэд хяналт хийхэд: *Санхүүгийн албанаас ажилтны ажилласан хоногийг тооцон ажлын хөлсийг сарын эхээр 5-ны, сарын сүүлээр 20-ны өдрүүдэд сард 2 удаа олгож мэдээллийг албан мэйлээр илгээсэн байна. *Багш нарын илүү цагийн хөлсийг холбогдох сургалтын албанаас кредит цагийн тооцоо, мэдээллийг гаргаж захирлаар батлуулан олгож ажилласан байна.	Ажилтан, ажилчид санхүүтэй холбоотой мэдээ мэдээллийг үнэн зөв хүрээж ажиллаж байна.
		Эд хөрөнгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, ашиглалт, санхүүгийн бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих	2024.6,7,8 саруудад	*Эд хөрөнгийг хагас жил болон жилийн эцсээр тооллого хийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажилласан. *Өмч хамгаалах зөвлөл тавилга эд хогшлийн ариг гамтай ашиглах үргүй зардал гаргахгүй байх, засварлах ажлыг зохион байгуулж ажилласан байна	 Эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд анхаарч ажиллаж байна.
7	3.5 Тайлан	Хяналт шалгалтын үйл ажиллагаа, дүн, ажлын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар улиралд 1 удаа хамт олонд тайлагнах	2024.12	2024 оны дотоодын хяналт, шалгалтыг зохион байгуулах явцын үр дүнг жилийн эцсээр хамт олонд тайлагналаа. Тайланд анхаарч ажиллах шаардлагатай байгаа асуудлуудыг хэлэлцэж: *Бакалаврын болон Коосэн коллежийн оюутнуудын хичээл таслалт, хоцролт болон идэвх оролцооны зөрчлийг хэлэлцэж анги бүрт эцэг эхийн хурал хийсэн. *Коосэн коллежийн оюутнуудын хувцас жигдрэлтэд анхаарч ажиллахыг анги удирдсан багш нарт үүрэг болгосон. *Сургууль болон сургуулиас гадуур үүссэн оюутны сахилга батын зөрчил хийгээд оюутны байранд үүссэн харилцаа хандлагын асуудалд онцгойлон анхаарч асуудлыг шийдвэрлэн ажилласан. *0.7 доош голчтой суралцсан оюутнуудад сургалт чанарын албанаас сануулга, зөвлөмж өгч ажилласан. *Багш нарын ажлын цагийг Timely системээр хянан ажиллаж эхэлсэн. *Албатуудын дарга нартай үр дүнгийн гэрээ хийж ажилласан үр дүнтэй байна.	Сургалтын үйл ажиллагаа, чанар, багш нарын заах арга зүй болон зохион байгуулалтад хяналт тавьж хэрэгжүүлсэн ажлууд: 1. Хичээл зохион байгуулалт, цаг ашиглалт 2. Хичээлийн хуваарийн давхардалт 3. Оюутны ирц, идэвх оролцоо, сурлагын чанар 4. Ажилчдын цаг ашиглалт, идэвх санаачилга, хамтын ажиллагаа 5. Байгууллагын дэг соёл, харилцаа хандлага төлөвшүүлэлт

Өмнөговь аймаг дахь Технологийн Дээд Сургуулийн
Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах комиссын жилийн ажлын тайлан: Дотоод хяналт, шалгалтын баг

2025.02.12